



ᠮᠣᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰ
ᠤᠨᠳᠤᠰᠨᠢᠮᠤ
ᠰᠤᠲᠤᠳᠢᠰᠲᠢᠭᠢᠨ
ᠮᠤᠳᠤᠳᠤ

ХҮН АМЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ОЙЛГОЛТ ХЭРЭГЛЭЭ



АГУУЛГА

- Хүн амын статистикийн мэдээллийн эх, үүсвэр, давтамж
- Хүн амын үзүүлэлтүүд, тэдгээрийг тооцох аргачлал
 - ❖ *Хүн ам, өрх, түүний өсөлт, бүтэц*
 - ❖ *Шилжих хөдөлгөөн, хотжилт*
 - ❖ *Дундаж наслалт*
 - ❖ *Хэтийн тооцоо*
 - ❖ *Гэрлэлт, цуцлалт*
- Хүн амын статистик мэдээллийн тархаалт



УНДСНИИ СТАТИСТИК

ХҮН АМЫН Мэдээллийн эх үүсвэр, давтамж

Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнгээс 5,10 жилд 1 удаа,

Суурин хүн амын жилийн эцсийн мэдээгээр жил бүр

ОӨУБЕГ-ын хагас жил, жилийн хүн ам ердийн болон шилжих хөдөлгөөний мэдээ

Эрүүл мэндийн яамны мэдээгээр улирал бүр



МОНГОЛ
УЛСЫН
ҮНДЭСНИЙ
СТАТИСТИК

Хүн амын статистикийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1/1-д заасны дагуу

- Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын нийтлэг аргачлалд нийцүүлэх
- Нэгдсэн үзүүлэлтийн систем бий болгох, статистикийн мэдээллийг цуглуулах,
- Нэгтгэн боловсруулж, ашигладаг бүх шатны байгууллагууд болон ажилтнууд, хэрэглэгчдийг нэгдсэн ойлголт, тодорхойлолт, аргачлалаар хангах, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэх зорилгоор “Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал”-ыг ҮСХ-ны даргын 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/149 тоот тушаалаар баталж мөрдүүлээд байна.



Улсын Статистик

Хүн ам ба хөгжлийн харилцан уялдаа





Хүн амын өсөлт

- УИХ-ын 2004 оны 4-р сарын 23-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор *“Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”*-ыг баталсан.
- Уг бодлогод хүн амын өсөлтийн талаар “хүний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн чөлөөт сонголт бүхий зохистой төрөлтийг дэмжиж, өвчлөл, нас баралтыг бууруулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана.” гэж заасан байдаг.
- Хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх үүднээс *төрөлт, гэр бүлийг* дэмжих бодлого баримталж байна.



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИК

Хүн амын тоо

- **“Хүн амын тоо”** гэдэг нь тодорхой хугацаанд тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ.
 - Оршин суугаа хүн ам
 - Бэлэн хүн ам
- Монгол Улсад одоогоор **“Нийт хүн амын тоо”** болон **“Оршин суугаа хүн амын тоо”** гэдэг 2 ойлголтыг хэрэглэж байна.
 - Монгол Улсын хүн ам гэж МУ-ын нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар) оршин суугаа МУ-ын харьяат иргэд болон гадаадад амьдарч байгаа МУ-ын харьяат иргэдийн нийлбэр дүн юм.
 - Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам гэж МУ-ын нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар) оршин суугаа МУ-ын харьяат иргэд, гадаадын харьяат болон харьяалалгүй иргэдийн нийлбэр дүн юм.
- **Хүн амын жилийн дундаж тоо:** Тайлант оны эхний болон эцсийн хүн амын тооны дунджаар илэрхийлэгдэнэ.

$$\text{Хүн амын жилийн дундаж тоо} = \frac{\text{Жилийн эхний хүн амын тоо} + \text{Жилийн эцсийн хүн амын тоо}}{2}$$



УНДСНИЙ СТАТИСТИК
National Statistical Office of Mongolia

ХҮН АМ ЗҮЙН ТЭНЦЛИЙН ТОМЪЁО

- Хүн амын өсөлт өөрчлөлтийн үндсэн 3 бүрэлдэхүүн болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний тоо хэмжээнд үндэслэн хоёр хугацааны хоорондох хүн амын өсөлт, өөрчлөлтийг тооцох арга юм.

$$XA_{(ж.эц)} = XA_{(ж.эх)} + \text{Төрөлт} - \text{Нас баралт} + \text{Шилжин ирэлт} - \text{Шилжин явалт}$$



МОНГОЛЫН УНДЭСНИЙ СТАТИСТИК

Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь

- Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь нь өгөгдсөн хугацаан дахь хүн амын тооны бодит өсөлт, бууралтыг хувиар харуулах энгийн арга юм.

$$\begin{array}{l} \text{Хүн амын жилийн} \\ \text{дундаж өсөлтийн} \\ \text{хувь} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Тайлат оны хүн} \\ \text{амын тоо} \end{array} - \begin{array}{l} \text{Суурин оны хүн} \\ \text{амын тоо} \end{array}}{\begin{array}{l} \text{Суурин болон} \\ \text{тайлант оны} \\ \text{хоорондох хугацаа} \end{array}} * \begin{array}{l} \text{(Суурин оны хүн} \\ \text{амын тоо)} \end{array} * 100$$



УНДСНИИ СТАТИСТИК

Хүн амын ердийн цэвэр өсөлт / бууралт, түүний коэффициент

- Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүг хүн амын ердийн **цэвэр өсөлт** /бууралт/ гэх бөгөөд уг зөрүүг жилийн дундаж хүн амд эзлэх хувиар ирэхийлснийг **хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралтын коэффициент** гэнэ.

Хүн амын ердийн цэвэр өсөлт = Төрөлт-Нас баралт

$$\text{Хүн амын ердийн цэвэр өсөлтийн коэффициент} = \frac{\text{Төрөлт-Нас баралт}}{\text{Жилийн дундаж хүн ам}} * 1000$$




УНДСНИИ СТАТИСТИК


ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ

- ❑ **Хүн амын нас, хүйсийн бүтэц гэдэг** нь тухайн нас, хүйсийн бүлэг дэх хүн амын тоо хэмжээний тархалтыг хэлдэг.
- ❑ Нас, хүйсийн бүтцийн судалгаа нь тухайн хүн амын өнөөгийн байдал, түүнээс гарч болох үр дагавар, ирээдүйн төлвийг тодорхойлоод зогсохгүй цаашид баримтлах бодлого, төлөвлөлтийн **үндэс суурь** болдог байна.
- ❑ Хүн амын нас, хүйсийн бүтэц ямар байгааг
 - *абсолют тоо*,
 - *хувийн жин*, зураг ашиглан харуулж болдог.
- ❑ Насны бүтэц нь залуужих, идэрших, хөгшрөх гэсэн 3 үндсэн хандлагад хуваагддаг.


Залуу насны бүтэцтэй



Идэр насны бүтэцтэй



Хөгшин насны бүтэцтэй



МОНГОЛЫН УНДЭСНИЙ СТАТИСТИК






МОНГОЛ
УЛСЫН
СТАТИСТИК
АГЫН

Хүн амын нас, хүйсийн суварга

□ Хүн амыг нас, хүйсээр хуваарилан харуулдаг босоо байрлалтай **диаграмм юм**. Суваргыг бодит тоогоор болон хувийн жингээр байгуулж болно.





УНДСНИИ СТАТИСТИК

Хүн ам зүйн ачаалал, хүн амын хүйсийн харьцаа

□ **Хүн ам зүйн ачаалал:** Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо (15 хүртлэх, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг харуулна.

$$\text{Хүн ам зүйн ачаалал} = \frac{\text{(0-14) насны хүн амын тоо} + \text{65 ба түүнээсдээш насны хүн амын тоо}}{\text{(15-64) насны хүн амын тоо}} * 100$$

□ **Хүйсийн харьцаа:** 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлнэ.

$$\text{Хүйсийн харьцаа} = \frac{\text{Эрэгтэй хүн амын тоо}}{\text{Эмэгтэй хүн амын тоо}} * 100$$



ᠮᠣᠩᠭᠣᠯᠢ
ᠤᠨᠳᠤᠰᠨᠢ
ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠭ

Өрх, өрхийн гишүүн

□ Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ.

Өрхийг бүтцээр нь

- Ганц бие өрх
- Ам бүлээрээ байгаа өрх;
- Нийлмэл өрх;
- Холимог өрх гэж ангилдаг.

□ Өрхийн гишүүд хэнийгээ **өрхийн тэргүүлэгч** гэж үзэхээ сайн дураар шийдвэрлэнэ. Гэхдээ өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-гаас дээш насны бөгөөд өрхийн бусад гишүүд өрхийн тэргүүлэгчээр өргөмжилсөн хүн байна.



МОНГОЛЫН
УНДСНИИ
СТАТИСТИК

Өрхийн ам бүлийн дундаж тоо

□ **Өрхийн ам бүлийн дундаж тоо:** Энэ үзүүлэлт нь нэг өрхөд ногдох хүний тоог илэрхийлнэ.

$$\text{Өрхийн ам бүлийн дундаж тоо} = \frac{\text{Жилийн дундаж хүн амын тоо}}{\text{Нийт өрхийн тоо}}$$



Төрөлт, төрөлтийн үзүүлэлтүүд

- ❑ **Төрөлт** нь хүн амын өсөлт болон насны бүтцийн өөрчлөлтийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.
- ❑ **Төрөлтийн ерөнхий коэффициент:** Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

$$\text{Төрөлтийн ерөнхий коэффициент} = \frac{\text{Төрөлтийн тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$

- ❑ **Төрөлтийн тусгай коэффициент:** тухайн жилийн төрөх насны (15-49 насны) 1000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ. Энэ үзүүлэлт нь хүн амын насны бүтцээс үл хамаарч, тухайн жилийн төрөлтийн дундаж түвшинг харуулдаг.

$$\text{Төрөлтийн тусгай коэффициент} = \frac{\text{Төрөлтийн тоо}}{\text{15-49 насны эмэгтэйн тоо}} * 1000$$



МОНГОЛЫН
УЛСЫН
СТАТИСТИК
ТӨВӨН

ТӨРӨЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

□ **Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент:** тухайн насны бүлгийн 1000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлэх бөгөөд тухайн насны бүлэг дэх эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, промиллээр илэрхийлнэ.

$$\text{Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент} = \frac{\text{Тухайн насны бүлгийн төрсөн хүүхдийн тоо}}{\text{Тухайн насны бүлгийн эмэгтэйн тоо}} * 1000$$

□ **Төрөлтийн нийлбэр коэффициент:** Нэг эмэгтэйн (нөхөн үржихүйн амьдралын хугацаагаа дуустал нас барахгүй ба тухайн жилийн тухайн насны бүлэг дэх төрөлтийн түвшин хадгалагдана гэж үзвэл) нөхөн үржихүйн амьдралынхаа сүүл үе гэхэд төрүүлсэн байх нийт хүүхдийн тоог илэрхийлнэ. Төрөлтийн нийлбэр коэффициентийг бүх эмэгтэйчүүдийн тухайн цаг үе дэх төрөлтийн тоог нэгтгэн, нэг эмэгтэйд ногдохоор тооцдог.

$$\text{Төрөлтийн нийлбэр коэффициент} = \frac{\sum \text{НБТК} * \text{Насны бүлгийн интервалын урт}}{1000} * 5$$

ТӨРӨЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- **Нөхөн үржихүйн цэвэр коэффициент:** Тухайн жилийн нас баралтын түвшинг тооцсон тохиолдолд нэг эмэгтэйн (эсвэл 1000 эмэгтэйн) амьдралын хугацаандаа төрүүлэх охидын тоог илэрхийлнэ.

$$\text{Нөхөн үржихүйн цэвэр коэффициент} = \frac{\sum \text{НБТК (эм)} * \text{Насны бүлгийн интервалын урт} * \text{Охидын төрснөөс хойш эхийн насанд хүртэл амьд байх магадлал}}{1000}$$

- **Нөхөн үржихүйн бохир коэффициент :** Нэг эмэгтэйн (эсвэл 1000 эмэгтэйн) амьдралын хугацаандаа төрүүлэх охидын тоог илэрхийлнэ.

$$\text{Нөхөн үржихүйн бохир коэффициент} = \frac{\sum \text{НБТК (эм)} * \text{Насны бүлгийн интервалын урт}}{1000} * 5$$



МОНГОЛ
УНДСНИЙ
СТАТИСТИК

Нас баралт, нас баралтын үзүүлэлтүүд

- ❑ **Нас баралт нь** хүн төрөлхтний дунд гарч буй нөхөн үржихүйн үзэгдлийн нэг юм. Хүн амын амьжиргааны түвшин, амьдралын хэв маяг, эрүүл ахуйн нөхцөл, өвчлөл нь нас баралтын түвшинд нөлөө үзүүлдэг учир энэ үзүүлэлтийг нас баралтын шалтгаанаар нь тодорхойлж болно
- ❑ **Нас баралтын ерөнхий коэффициент:** Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

$$\text{Нас баралтын ерөнхий коэффициент} = \frac{\text{Нас барсан хүний тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$

- ❑ **Насны бүлэг дэх нас баралтын коэффициент:** Тухайн насны бүлгийн 1000 хүнд ногдох тухайн насны бүлгийн нас барсан хүний тоо бөгөөд тухайн насны бүлэгт нас барсан хүний тоог мөн насны бүлгийн хүн амын тоонд харьцуулж, промиллээр илэрхийлнэ.

$$\text{Насны бүлэг дэх нас баралтын коэффициент} = \frac{\text{Тухайн насанд нас барсан хүний тоо}}{\text{Тухайн насны бүлгийн хүний тоо}} * 1000$$



МОНГОЛ УЛСЫН ҮНДСНИЙ СТАТИСТИК

Шилжих хөдөлгөөний бодлого

- Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод дотоод шилжих хөдөлгөөний талаар дөрвөн заалт байдаг. Үүнд:
 - Бүсийн тулгуур төв, нийслэлийн дагуул хотыг хөгжүүлэх хот, суурин газарт чиглэсэн шилжих хөдөлгөөний эрчимжилтийг зохицуулна.
 - Хүний чөлөөтэй шилжин суурьших эрхийг хүндэтгэж, ажиллах амьдрах газраа сонгох нөхцлийг бүрдүүлнэ.
 - Орон нутагтаа тав тухтай амьдран суурьших нөхцлийг хангаж, байгаль орчин, эдийн засгийн болзошгүй эрсдэлээс хамгаална.
 - Шилжин суурьшигчдын нийгмийн үйлчилгээнд ногдох зардлыг оршин сууж байсан аймаг, сумын төсвөөс шилжин суурьшсан газарт нь шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.



Шилжих хөдөлгөөн, хотжилт

- Тухайн улс, орны хилийн хүрээн доторх засаг захиргааны нэгж хоорондох, түүнчлэн байршлын хувьд (хот, хөдөө) явагдах *хүн амын суурьшлын өөрчлөлтөөр* тодорхойлогдоно.
- Шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлт нь *шилжин ирэгчдийн тоо, шилжин явагчдын тоо* болно.
- Улс, орнууд хүн амаа хотын эсвэл хөдөөгийн гэж ангилахдаа ялгаатай ханддаг. Монгол Улсын хот, тосгоны эрх зүйн байдлын тухайн хуулийн 3.1-д *хот*, ”, 3.2-д *тосгоныг* тодорхойлсон байдаг.
 - Хотын хүн ам, өрх: Нийслэл, аймгийн төв, тосгонд оршин суугаа бүх хүн ам, өрхийг хамруулна.
 - Хөдөөгийн хүн ам, өрх: Сумын төв (аймгийн төвийн сумыг оруулахгүй), хөдөөд оршин суугаа бүх хүн ам, өрхийг хамруулна.



Дотоод шилжин ирэлт, явалтын коэффициент

- Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох **шилжин ирсэн** хүн амын тоог илэрхийлнэ.

$$\text{Шилжин ирэлтийн коэффициент} = \frac{\text{Шилжин ирсэн хүн амын тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$

- Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох **шилжин явсан** хүн амын тоог илэрхийлнэ.

$$\text{Шилжин явалтын коэффициент} = \frac{\text{Шилжин явсан хүн амын тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$



МОНГОЛ
УНДСНИИ
СТАТИСТИК

Дотоод шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент

- Шилжин ирсэн, шилжин явсан хүн амын тооны зөрүүг жилийн дундаж хүн амд харьцуулж тодорхойлно. Энэ коэффициент нь сөрөг гарвал шилжин явалт өндөр, эерэг гарвал шилжин ирэлт өндөр байгааг илтгэнэ.

$$\text{Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент} = \frac{\text{Шилжин ирсэн хүн амын тоо} - \text{Шилжин явсан хүн амын тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$



МОНГОЛ УЛСЫН ҮНДСНИИ СТАТИСТИК

Байршилын талаарх бодлого

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод хүн амын байршлын талаар:

- Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасган байгаль орчны даац, түүний нөөцтэй уялдуулан хүн амын зохисгүй бөөгнөрлийг сааруулж, **дагуул хот, бүсийн тулгуур төвүүд** болон **бүлэг сууринг түшиглэсэн** орон нутагтаа суурин амьдрах хүн амын байршлыг дэмжинэ.
- Байгаль, орчиндоо зохицсон бэлчээрийн болон фермерийн аж, ахуй эрхэлж, нүүдлийн, хагас суурин хэвшлээр амьдарч буй хүн амд хүргэх орчин үеийн **техникийн дэвшилд суурилсан зам, холбоо, эрчим хүч, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, чанарыг** тогтвортой сайжруулах бодлого баримтлана гэж заасан.



ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠳᠡᠰᠡᠨᠢᠯᠢᠰᠲᠢᠭᠤᠨ
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠰᠤᠳᠤᠰᠡᠨᠢᠯᠢᠰᠲᠢᠭᠤ

Хотжилт, хотжилтын түвшин, хүн амын нягтрал

- Хотжилтын түвшин нь хот газарт амьдарч байгаа хүмүүсийн тоог харуулах үзүүлэлт юм. Хотжилтын түвшинг тодорхойлох 2 төрлийн хэмжүүр байдаг.
 1. **Хотын хүн амын хувийн жин:** Хотжилтын түвшинг тодорхойлох хамгийн ерөнхий бөгөөд өргөн хэрэглэдэг хэмжүүр юм.
 2. **Хот, хөдөөгийн хүн амын харьцаа:** Хөдөөгийн 100 хүн амд хотын хэдэн хүн ногдож байгааг харуулна.
- **Хүн амын нягтрал** гэдэг нь нэгж газар нутагт ногдох хүн амын тоог илэрхийлнэ.



МОНГОЛЫН УНДСНИЙ СТАТИСТИК

Хотжилтын үзүүлэлтүүд

Хотын хүн амын хувийн жин;

$$\text{Хотын хүн амын хувийн жин} = \frac{\text{Хотын хүн амын тоо}}{\text{Нийт хүн амын тоо}} * 100$$

Хот, хөдөөгийн хүн амын харьцаа;

$$\text{Хот, хөдөөгийн харьцаа} = \frac{\text{Хотын хүн амын тоо}}{\text{Хөдөөгийн хүн амын тоо}} * 100$$

Хүн амын нягтрал;

$$\text{Хүн амын нягтрал} = \frac{\text{Жилийн дундаж хүн амын тоо}}{\text{Нутаг дэвсгэрийн хэмжээ}}$$



УНДСНИИ СТАТИСТИК

Дундаж наслалт

- Шинээр төрсөн (төрөх үеийн) хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг (жил) **дундаж наслалт** гэнэ.
- Дундаж наслалтын тооцоонд:
 - Насны бүлгээрх нас баралтын тоо
 - Насны бүлгээр хүн амын тоо,
 - Төрөх үеийн хүйсийн харьцаа,
 - Нялхсын эндэгдлийн түвшинг ашигладаг бөгөөд шинээр төрсөн хүүхдийн төрөх үед байсан нас баралтын түвшин уг хүүхдийн амьдралынх нь хугацаанд хэвээр хадгалагдаж байх таамаглалыг дэвшүүлж тооцоог хийдэг.



ХЭТИЙН ТООЦОО, ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

- Төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний ирээдүйн чиг хандлагын талаарх төсөөлөл дээр үндэслэн хүн амын тооны ирээдүйн өөрчлөлтийг тооцох тооцоо юм.
- Хэтийн тооцоог үндсэн 3 зорилгоор хийдэг. Үүнд:
 - Нийгэм, эдийн засгийн төлөвлөлт хийх
 - Хүн амын бодлого боловсруулах
 - Судалгаа, шинжилгээнд ашиглах
- Хэтийн тооцоог хамрах хугацааны хувьд
 - Үндэсний
 - Бүс нутгийн түвшинд хийх боломжтой.
- Хэтийн тооцоог хийх хамгийн зохимжтой хугацаа нь **25-30 жил** юм.



ХЭТИЙН ТООЦОО, ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

- Хэтийн тооцоог хийхдээ хүн амын өсөлтийн үндсэн бүрэлдэхүүн болох **төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний** ирээдүйн хандлагыг урьдчилан төсөөлж, таамаглал дэвшүүлнэ.
- Хэтийн тооцоог **дээд, дунд, доод** гэсэн 3 хувилбараар хийнэ. Ингэхдээ таамаглалыг дараах байдлаар тавьдаг.
 - Хүн амын өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүд ирээдүйд өөрчлөгдөхгүй буюу хэтийн тооцоо явуулж буй эхэн үеийн түвшинд үлдэнэ.
 - Төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөн нь өмнөх үед хэрхэн өөрчлөгдсөн, тэр хандлагаараа өөрчлөгдөнө.
 - Хүн амын бүрэлдэхүүн хэсгүүд дээрх хоёроос өөр чиг хандлагаар өөрчлөгдөнө.



МОНГОЛ УЛСЫН
УНДЭСНИЙ
СТАТИСТИК

Гэр бүлийн талаарх бодлого

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод гэр бүлийн хөгжлийн талаар:

- **Гэр бүл нь** хүний амьдралын **анхдагч** орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын төвд байлгана.
- Гэр бүлийн харилцаанд **жендэрийн тэгш байдлыг** хангана.
- Үндэсний өв соёл, удам угсаагаа хүндэтгэн ирсэн **ёс заншлыг** хүүхэд, залуучуудад уламжлуулан хөгжүүлэхийг дэмжин урамшуулна.
- Өмчийн харилцаанд гэр бүлийн гишүүн бүрийг **тэгш эрхтэйгээр** оролцуулах, эдийн засгийн талаар **бие даан хөгжих**, хөдлөх болон **үл хөдлөх хөрөнгө** эзэмших нөхцлийг бүрдүүлнэ.
- Гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийн ачааллыг багасгах зорилгоор тусгай асаргаа шаардлагатай бага насны хүүхэд, өндөр настан, тахир дутуу иргэдэд зориулсан **нийгмийн үйлчилгээг** бий болгон хөгжүүлнэ.
- Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах **эрх зүй, зан үйл, хандлагын эерэг орчин** бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалалд эцэг, эхийн **гэр бүлд** үзүүлэх дэмжлэгийн хүрээг өргөжүүлнэ гэж заасан байдаг.



МОНГОЛ
УНДЭСНИЙ
СТАТИСТИК

Гэрлэлт, гэр бүл цуцлалт

□ **“Гэр бүл”** гэж голдуу гэрлэлт, төрөлт эсвэл үрчлэлтээр холбогдон хамтдаа амьдарч буй хоёр ба түүнээс олон тооны хүнийг хэлнэ.

□ Гэрлэлтийн байдал:

- Огт гэр бүл болоогүй
- Гэрлэсэн: Батлуулсан гэр бүлтэй
Батлуулаагүй гэр бүлтэй
- Бэлбэсэн
- Тусгаарласан
- Цуцалсан



Гэрлэлтийн үзүүлэлтүүд

- **Гэрлэлтийн ерөнхий коэффициент:** Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлнэ.

$$\text{Гэрлэлтийн ерөнхий коэффициент} = \frac{\text{Гэрлэлтийн тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$

- **Гэрлэлтийн тусгай коэффициент:** Тухайн жилийн 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлнэ.

$$\text{Гэрлэлтийн тусгай коэффициент} = \frac{\text{Гэрлэлтийн тоо}}{\text{15 ба түүнээс дээш насны хүн амын тоо}} * 1000$$

- **Насны бүлэг дэх гэрлэлтийн коэффициент:** Тухайн жилийн тодорхой насны бүлэг дэх 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлнэ.

$$\text{Нас, хүйсийн бүлэг дэх коэффициент} = \frac{\text{Тухайн насны бүлэг дэх гэрлэлтийн тоо}}{\text{Тухайн насны бүлгийн хүн амын тоо}} * 1000$$



Гэр бүл цуцлалтын үзүүлэлтүүд

- **Цуцлалтын ерөнхий коэффициент:** Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох гэр бүл цуцлалтын тоог илэрхийлнэ.

$$\text{Цуцлалтын ерөнхий коэффициент} = \frac{\text{Цуцлалтын тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000$$

- **Цуцлалтын тусгай коэффициент:** Тухайн жилийн 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутамд ногдох гэр бүл цуцлалтын тоог илэрхийлнэ.

$$\text{Цуцлалтын тусгай коэффициент} = \frac{\text{Цуцлалтын тоо}}{\text{15 ба түүнээс дээш насны хүн амын тоо}} * 1000$$

- **Насны бүлэг дэх цуцлалтын коэффициент:** Тухайн жилийн тодорхой нас-хүйсийн бүлгийн 1000 хүн амд ногдох тухайн нас-хүйсийн бүлэг дэх гэр бүл цуцлалтын тоог илэрхийлнэ.

$$\text{Нас, хүйсийн бүлэг дэх цуцлалтын коэффициент} = \frac{\text{Тухайн насны бүлэг дэх цуцлалтын тоо}}{\text{Тухайн насны бүлгийн хүн амын тоо}} * 1000$$



Мэдээллийн тархаалт

Статистикийн сарын бюллетень, танилцуулга

Статистикийн жилийн эмхэтгэл

Хүн ам, орон сууцны тооллогын үр дүн, илтгэл,
сэдэвчилсэн судалгаа

ҮСХ-ны вэб сайт www.nso.mn



ᠠᠨᠬᠠᠠᠷᠠᠯᠤᠲᠠᠪᠦᠰᠠᠨᠳᠤᠪᠠᠶᠢᠷᠯᠠᠯᠠᠭᠠ

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.